

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2020 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН МЭДЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2020.12.28

Арвайхээр

Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2008 оны 44 дүгээр захирамжаар батлагдсан “Иргэдээс аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс албадад гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай журам”-ыг хэрэгжүүлэн сум, хэлтэс, агентлагуудыг арга зүйн удирдлагаар ханган улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах эх үүсвэрээр хүлээн авч байна. Үүнд:

- Төрийн захиргаа болон үйлчилгээний байгууллагууд;
 - Аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 7032-1111 дугаарын нээлттэй утсаар;
 - Аймгийн албан ёсны цахим хуудас /www.uvurkhangai.mn/ болон сум, агентлагуудын цахим хуудсаар;
 - Агентлаг, сумдын ЗДТГ-ын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр;
- Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-өөр тус тус өргөдөл, гомдлыг хүлээн авч байна.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх агентлаг, төсөвт байгууллагад 2020 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 22601 өргөдөл, гомдол, санал ирүүлсэн байна. Үүнээс өргөдөл 21218 буюу 93.8 хувь, гомдол 1008 буюу 4.4 хувь, санал 375 буюу 1.6 хувийг тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 22601 өргөдөл, гомдол, санал ирсэний 22362 буюу 98.9 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдэж, 1490 буюу 6.5 хувь нь бусад байгууллагад шилжүүлж, 239 буюу 1.0 хувь нь шийдвэрлэх хугацаа болоогүй байна.

Нийт ирүүлсэн өргөдлийг хэлбэрээр нь авч үзвэл бичгээр 20574 буюу 91.0 хувь, утсаар 1506 буюу 6.6 хувь, биечлэн ирүүлсэн 247 буюу 1.0 хувь, цахимаар 272 буюу 1.2 хувийг тус тус эзэлж байна.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдол, саналыг агуулгаар нь авч үзвэл нийгмийн халамжтай холбоотой 5964 буюу 26.3 хувь, газар эзэмших, өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой 1772 буюу 7.8 хувь, ажилд орох чөлөөлүүлэх 1729 буюу 7.6 хувь, иргэний бүртгэл, мэдээлэл 1725 буюу 7.5 хувь, , хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудал 648 буюу 2.8 хувь, материал, мөнгөн тусламж хүссэн 313 буюу 1.4 хувийг тус тус эзэлж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг даргад хандаж мөнгөн тусламж хүсч өргөдөл ирүүлсэн 109 иргэнд 56.3 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлж, өөрийн амьдрах гэр оронгүй, хүнд өвчтэй, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 3 иргэнд тус бүрт нь гэр олгов.

Тайлант онд Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д нийт 45 иргэн гомдол, санал гаргаж хандсан байна. Нийт ирүүлсэн гомдлын төрлөөр нь авч үзвэл өвөлжилт хүндрэлтэй байгаан улмаас отор нүүдэлтэй холбоотой 10,

нийгмийн халамжийн чиглэлээр 10, төрийн үйлчилгээтэй холбоотой 7, томилгоотой холбоотой 5, ковид цар тахлын урьдчилсан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой 3, байгаль орчноо хамгаалах чиглэлээр 2 гомдол ирүүлсэн байна. Гомдол 32 буюу 71.1 хувь, санал, хүсэлт 13 буюу 28.9 хувь байна. Нийт 45 санал, гомдлоос 42 гомдол буюу 93.3 хувийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж 3 гомдол шийдвэрлэх шатандаа байна.

Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсаар хүлээн авч нийт 866 өргөдөл, гомдол, санал ирснээс 627 буюу 99.2 хувь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна. Нийт ирсэн өргөдөл, гомдол, саналаас давхардсан тоогоор гомдол 666 буюу 76.9 хувь, мэдээлэл, тодруулга, санал 46 буюу 5.3 хувийг хүлээн авч нийт 866 өргөдөл, гомдол, санал ирснээс 848 буюу 97.9 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.

Тайлант онд долоо хоног бүрийн Мягмар гаригт хуралддаг аймгийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, агентлаг, албадын дарга нарын “Шуурхай хуралдаан”-ыг 28 удаа зохион байгуулж, 7032-1111 утсанд иргэдийн ирүүлсэн 632 санал, гомдлыг шийдвэрлэсэн талаарх мэдээллийг сонсч, 68 удаагийн үүрэг даалгаврыг байгууллагын удирдлагуудад өгч ажиллалаа.

“Ковид” цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Шуурхай хуралдаан”-ыг зохион байгуулахгүй байж, иргэдийн өргөдөл, гомдол, саналыг цахим болон утсаар хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.

Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг 2020 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, хавсралтаар хүргүүлж байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

2020.12.12

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт өргөдөл, гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /Хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаа болоогүй	
1.	Аймгийн ЗДТГазар	381	368	57	0	13	96.5
2.	Агентлагууд	1747	1695	1	0	52	97.0
3.	Сумд	19607	19446	566	7	161	99.1
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	866	853	866	5	13	98.4
Дүн		22601	22362	1490	12	239	98.9

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТ /ХЭЛБЭРЭЭР/

2020.12.28

Арвайхээр

д/д	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахимаар	Утсаар	Биечлэн	Бусад
1.	Аймгийн ЗДТГазар	381	381	-	-	-	-
2.	Агентлагууд	1747	1598	22	87	40	-
3.	Сумд	19607	18575	248	577	207	-
4.	Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төв /70321111/	866	20	2	844	0	-
Дүн		22601	20574	272	1508	247	-
Хувь		100%	91.0%	1.2%	6.6%	1.0%	-

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, САНАЛ, ХҮСЭЛТИЙН АГУУЛГА /ХУВИАР/

2020.12.28

Арвайхээр

Аймгийн нэр	/тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/			
Өвөрхангай аймаг	Нийт өргөдөл, гомдол, санал 22601 ирсэн байна.	хүсэлт	21218	93.8%
		гомдол	1008	4.4%
		санал	375	1.6%
	Нийгмийн халамжийн үйлчилгээ	5964	26.3%	
	Газар эзэмших, өмчлөх, шилжүүлэхтэй холбоотой	1772	7.8%	
	Ажилд орох, чөлөөлүүлэх	1729	7.6%	
	Иргэний бүртгэл, мэдээлэл	1715	7.5%	
	Тэтгэвэр тогтоолгох, тэтгэмж хүссэн	1144	5.0%	
	Хөдөлмөр эрхлэлттэй холбоотой	648	2.8%	
	Материал, мөнгөн тусламж хүссэн	313	1.4%	
- Иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Аймгийн “Үйлчилгээний нэгдсэн төв”-ийн 70321111 дугаарын утсаар хүлээн авч байна. Өргөдөл, гомдол, санал нийт 866 ирсэнээс гомдол 666 буюу 76.9 хувь, мэдээлэл, тодруулга, санал 46 буюу 5.3 хувийг хүлээн авч нийт 866 өргөдөл, гомдол, санал ирснээс 848 буюу 97.9 хувь нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн байна.				

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ

НЭГТГЭСЭН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

П.МӨНХЗУЛ

